

**“АЛСЫН ХАРАА -2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН  
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 12 дугаар сарын 06

Улаанбаатар хот

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсө в	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар/	Хэрэгжилтийн хувь
				Он	Түвшин			
1	2	3	4	5	6	7	8	
Зорилт 2.7.Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.								
2.7.3.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	0.0	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	2022	Шинэчлэн хөгжүүлэх программ хангамжийн тоо-1	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	<p>Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар гадаадын иргэний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох эрх зүй, суурь нөхцөлийг сайжруулсан.</p> <p>Монгол Улсад 2000-2004, 2005-2008, 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай Монгол Улсын Их Хурлын 2001 оны 96, 2005 оны 29, 2009 оны 44 дүгээр тогтоолд жилд оруулж болох цагаач гадаадын иргэний тоог жил бүр 100-аас дээшгүй байхаар тус тус тогтоож байсан.</p> <p>Монгол Улсад 2013-2016 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлыг тогтоолгохоор 2013, 2015 онд тус тус Засгийн газраас Улсын Их Хуралд тогтоолын төслийг танилцуулж байсан ч батлагдаагүй. Мөн Монгол Улсад 2017-2020 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн барьж 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн чуулганаар хэлэлцүүлэхэд дэмжигдээгүй болно.</p> <p>Иймд “Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг холбогдох танилцуулгын хамт 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2075 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад</p>	100

						<p>хүргүүллээ.</p> <p>“Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн систем” (ISM) (одоо ашиглаж байгаа хуучин систем) дэх визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрөл, гадаадын иргэний бүртгэл хэсгийн үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд 10 дугаар сарын 30-ны өдрөөс бүрэн нэвтрүүлж, хүсэлтийг хүлээн авч эхэлсэнтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоон гарын үсгийн хэрэглээг жигдрүүлэх, шинэ систем ашиглах боломж олгох зорилгоор дээрх цахим үйлчилгээг 12 дугаар сарын 11-ний өдрөөс isf.mn системээр үзүүлж эхлэв.</p> <p>Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран 11 дүгээр сарын 02-ны өдрөөс танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системтэй холболоо.</p>	
Үнэлгээ: 100							